



ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДЭВШИЛ МАНДАЛ” ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛСОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: СТА/ҮЦ-2026/06-НӨ

Улаанбаатар хот
2026 он

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

“Лидер экаунт аудит” ХХК

Утас: 88112654, 88472789

Цахим хаяг: leaderaudit.25@gmail.com

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын хариуцлагын мэдэгдэл	3
Хараат бус Аудиторын тайлан	4 – 7
Аудитлагдсан санхүүгийн тайлан	8 – 11
Санхүүгийн байдлын тайлан	8
Орлогын дэлгэрэнгүй тайлан	9
Өмчийн өөрчлөлтийн тайлан	10
Мөнгөн гүйлгээний тайлан	11
Санхүүгийн тайлангийн тодруулга	12 – 17
Үйл ажиллагааны тухай	12
Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд	12 – 14
Санхүүгийн тайлангийн үзүүлэлт	15 – 17
Менежментийн захидал	18 – 19
Цаашид анхаарах асуудлууд	20 – 22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн тухай	20
Үнэ шилжилтийн тайлангийн тухай	20
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл баталгаажуулах тухай	21
Өглөгийн тухай	21
Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох тухай	22

ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК-д

Удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Энэхүү тайланд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй уншигдах дараах мэдэгдэл нь "Дэвшил мандал" Хувьцаат Компанийн (Цаашид ХК гэх) 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

"Дэвшил мандал" ХК-ийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв бэлтгэх, компанийн өмч хөрөнгийг хамгаалах, залилан бусад зөрчил дутагдлаас сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг авах үүрэгтэй.

Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлага ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж үүгээр мэдэгдэж байна.

"Дэвшил мандал" ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх энэхүү тайланг хүлээн зөвшөөрч батлав.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
НЯГТЛАН БОДОГЧ



С.АМАРМАНДАХ
М.АМАРБАЯР



“ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК

2026 оны 2 сарын 10 өдөр

Монгол улс 14230, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Парисийн гудамж-42, Ай Си Тауэр 607 тоот
Утас: 88472789, 88112654
И-мэйл: leaderaudit.20@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ДЭВШИЛ МАНДАЛ ХК-ИЙН УДИРДЛАГАД

Санал дүгнэлт

Бид “Дэвшил мандал ХК”-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “Дэвшил мандал ХК” 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын сандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Аудитын явцад бидний олж авсан баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал

байдаг. Харин бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудитын тайлан багтаагүй байдаг. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болгох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Гэхдээ алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв байгууллагын тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд байгууллагын тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Лидер экаунт аудит ХХК-ийн
Захирал П.Шаравхорол

2026 оны 2 дугаар сарын 10-ны өдөр
Улаанбаатар хот

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДЭВШИЛ МАНДАЛ ХК-ИЙН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

		(төгрөгөөр)	
Үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрнгө	3.1	16,500,261.00	16,527,659.00
Дансны авлага		-	-
Татвар, НДШ-ийн авлага	3.2	846,100.00	846,100.00
Бараа материал	3.3	10,600.00	10,600.00
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3.4	1,598,000.00	8,516,521.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		18,954,961.00	25,900,880.00
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	3.5	8,872,920.00	8,450,400.00
Биет бус хөрөнгө		-	-
Эргэлтийн бус хөрнгө		8,872,920.00	8,450,400.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		27,827,881.00	34,351,280.00
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг		-	-
Татварын өр		-	-
НДШ-ийн өглөг		-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	3.6	72,544,506.00	97,444,506.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн		72,544,506.00	97,444,506.00
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		72,544,506.00	97,444,506.00
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Хувийн өмч	3.7	10,563,000.00	10,563,000.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		5,212,000.00	5,212,000.00
Хуримтлагдсан ашиг/алдагдал		(60,491,625.00)	(78,868,226.00)
Эзэмшигчдийн өмчийн дүн		(44,716,625.00)	(63,093,226.00)
НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		27,827,881.00	34,351,280.00

*Энэхүү санхүүгийн тайлангийн 10-17 дугаар хуудсан дах тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн сэлбигүй хэсэг болно.

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

ДЭВШИЛ МАНДАЛ ХК-ИЙН АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

Үзүүлэлт	Тодуулга	Өмнөх он	(төгрөгөөр)
			Тайлант он
Борлуулалтын орлого	3.8	-	-
Борлуулалтын өртөг		-	-
Нийт ашиг(алдагдал)		-	-
Түрээсийн орлого		-	-
Хүүний орлого		-	-
Бусад орлого		-	-
Борлуулалт маркетингийн зардал		-	-
Ерөнхий удирдлагын зардал	3.9	14,645,014.00	18,376,601.00
Санхүүгийн зардал		-	-
Бусад зардал	3.10	5,100.00	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз		-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз		-	-
Татварын өмнөх ашиг(алдагдал)		(14,650,114.00)	(18,376,601.00)
Орлогын татварын зардал	3.11	-	-
Татварын дараах ашиг(алдагдал)		(14,650,114.00)	(18,376,601.00)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг/ алдагдал		-	-
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)		(14,650,114.00)	(18,376,601.00)

*Энэхүү санхүүгийн тайлангийн 10-17 дугаар хуудсан дах тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.

2.3 Аудит хийсэн эздийн өмчийн өөрчлөлтийн тайлан

ДЭВШИЛ МАНДАЛ ХК-ИЙН АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	(төгрөгөөр) Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,563,000.00	5,212,000.00	(45,841,511.00)	(30,066,511.00)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	10,563,000.00	5,212,000.00	(45,841,511.00)	(30,066,511.00)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(14,650,114.00)	(14,650,114.00)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,563,000.00	5,212,000.00	(60,491,625.00)	(44,716,625.00)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	10,563,000.00	5,212,000.00	(60,491,625.00)	(44,716,625.00)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(18,376,601.00)	(18,376,601.00)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,563,000.00	5,212,000.00	(78,868,226.00)	(63,093,226.00)

*Энэхүү санхүүгийн тайлангийн 10-17 дугаар хуудсан дах тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДЭВШИЛ МАНДАЛ ХК-ИЙН АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он (төгрөгөөр)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-	66,000.00
Бараа борлуулсан, үйлчилгээний орлого	-	-	-
Бусад мөнгөн орлого	-	-	66,000.00
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	10,964,188.00	-	24,938,602.00
Ажиллагчдад төлсөн	-	-	-
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	-	-
Бараа материал худалдан авахад төлсөн	-	-	-
Ашиглалтын зардалд төлсөн	-	-	-
Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	952,126.00	-	3,371,101.00
Хүүний төлбөрт	-	-	-
Татварын байгууллагад төлсөн	2,577,588.00	-	1,285,856.00
Даатгалын төлбөрт төлсөн	-	-	-
Бусад мөнгөн зарлага	7,434,474.00	-	20,281,645.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,964,188.00)	-	(24,872,602.00)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгө зарлага	-	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	-	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	10,725,000.00	-	24,900,000.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,725,000.00	-	24,900,000.00
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	-	-
Зээл, өрийн үнэт цаас төлбөрт төлсөн мөнгө	-	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	10,725,000.00	-	24,900,000.00
Валютын ханшийн зөрүү	-	-	-
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(239,188.00)	-	27,398.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,739,449.00	-	16,500,261.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,500,261.00	-	16,527,659.00

*Энэхүү санхүүгийн тайлангийн 10-17 дугаар хуудсан дах тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ТОДРУУЛГА 1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Бүртгэлийн дугаар:	810001005
Регистрийн дугаар:	2012421
Компанийн нэр:	"Дэвшил Мандал" ХК
Үүсгэн байгуулагдсан огноо:	2000.04.13
Үйл ажиллагаа:	Бетон эд анги үйлдвэрлэл /269500/ Хүнс, ундаа, тамхи голлосон төрөлжсөн бус барааны дэлгүүр /521100/ Гадаад худалдаа эрхлэх /4610/ Ажлын байрны түрээсийн үйлчилгээ эрхлэх /9529/ Төслийн зөвлөх үйлчилгээ эрхлэх /9411/
Дүрмийн сан:	10,563.0 мянган төгрөг
Хувьцаа эзэмшигч, гишүүний тоо:	94
Гүйцэтгэх захирал:	С.Амармандах
Компаний хаяг:	Дундговь, Сайнцагаан, 7-р баг, Нарлаг, 1
Утас:	99098866

ТОДРУУЛГА 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

1. СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагаа

Баримталсан стандартын талаар: Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт (СТОУС) болон Сангийн сайдын 361 дугаар тушаалаар баталсан Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" аргачлалын дагуу бэлтгэсэн.

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлагналын валют нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг байна. Компанийн санхүүгийн тайлангуудаа үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн байна.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг компани нь тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн гол бодолгууд

2.1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд мөнгө рүү түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлс хамаарна. Үүнд бэлэн мөнгө, банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө, хадгаламж зэргийг хамруулна.

2.2. Авлага

Компанийн авлага нь ажил, үйлчилгээг зээлээр борлуулж, төлбөрийг худалдан авагч болон бусад этгээдээс нэхэмжилж буй мөнгөний дүн юм.

2.3. Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнана. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс бараа материалыг иж бүрдэл болгох зардал ба борлуулах зардлыг хасч тооцно. Бараа материалын өртгийг жинлэсэн дундажийн өртгийг аргаар тооцох бөгөөд уг бараа материалыг одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбоотой гарсан зардлуудыг өртөгт шингээнэ.

2.4. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны удаа өртгөөр нь бүртгэх ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах тайлант үед үндсэн хөрөнгийг түүний өртгөөс аливаа хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралт хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

• Барилга байгууламж	25-40 жил
• Тоног төхөөрөмж	10 жил
• Тээврийн хэрэгсэл	10 жил
• Тавилга, эд хогшил	5-10 жил
• Компьютер, тоног төхөөрөмж	2-3 жил

Ашиглах эрхийн хөрөнгийн ашиглах хугацааг тодорхойлохдоо гэрээний нөхцөл эсвэл өмчлөлд байгаа ижил төстэй хөрөнгийн ашиглах хугацааны аль багаар тогтооно. Материаллаг дүнтэй үлдэх өртөг тооцоолол болон хөрөнгийн ашиглах хугацааны тооцооллыг багадаа жилд нэг удаа шинэчлэнэ. Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

2.5. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэх бөгөөд дараа үеэдэд түүний өртгөөс нь хуримтлагдсан хорогдуулга, үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр илэрхийлдэг. Биет бус хөрөнгийн ашиглагдах хугацааг дараах байдлаар тогтооно.

• Программ хангамж	Лизенцийн хугацаанд
• Газар эзэмших эрх	Эрхийн хугацаанд

2.6. Өр төлбөр

Харилцагч байгууллага, хувь хүнээс авсан бараа, ажил, үйлчилгээ авсныхаа төлөө тэдэнд мөнгө эсвэл бусад хөрөнгөөр төлбөр төлөх үүрэг хүлээсэн санхүүгийн хариуцлага бөгөөд ирээдүйд төлөгдөх өртгөөрөө хэмжигдэнэ.

2.7. Гадаад валютаарх ажил гүйлгээ болон үлдэгдэл

Гадаад валютуаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрийн Монгол банкны албан ханшаар төгрөгт хөрвүүлж төгрөг, юалютаар давхар бүртгэдэг. Гадаад валютуаар бүртгэгдсэн мөнгө хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн ханшаар хөрвүүлэн тайлагнадаг. Ажил гүйлгээнээс үүссэн валютын ханшийн олз, гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. жилийн эцсийн валютын ханшаар хөрвүүлсэнтэй холбоотой олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Зах зээлийн үнээр хэмжигддэгээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ хийгдсэн өдрийн түүхэн ханшаар бүртгэж, тайлант жилийн эцэст тэгшитгэл хийхгүй.

2.8. Хувьцаат капитал

Энгийн хувьцаа нь хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгийг харуулдаг бөгөөд хувьцааны нэрлэсэн үнэ болон хувьцааны тоо ширхэгийг санхүүгийн тайланд толилуулдаг.

2.9. Орлого

Бараа, ажил, үйлчилгээ борлуулсны орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлогыг хүлээн авсан, эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй бодит үнэ цэнээр хэмжих ба гарсан аливаа худалдаа, үйлчилгээний буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт зэргийг хассан цэвэр дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрдөг.

2.10. Санхүүгийн орлого ба санхүүгийн зардал

Санхүүгийн орлого нь хүүний орлогоос бүрдэх бөгөөд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд бүртгэгдэнэ. Хүүний орлогыг үр ашигт хүүний аргыг ашиглан орлогын тайланд хуримтлуулан хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрдэх ба ашиг алдагдлаар алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд бүртгэгдэнэ.

2.11. Зардал

Зардлыг нягтлан бодох бүртгэлийн аккрузль суурьт зарчмын дагуу эдийн засгийн ирээдүйн үр ашгийг хэмжиж болохуйц хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлэхээр байвал хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

ТОДРУУЛГА 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.1. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Касс дахь мөнгө	16,477,645.00	16,504,443.00
Банк дахь мөнгө	22,616.00	23,216.00
Нийт дүн	16,500,261.00	16,527,659.00

Харилцах дансны үлдэгдлийг дансны баталгаат хуулгаар, харин бэлэн мөнгөний тооллогод оролцоогүй болно.

3.2. Татвар, НДШ-ийн авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ААНОАТ-ын авлага	400,000.00	845,160.00
ХХОАТ-ын авлага	940.00	940.00
Нийт дүн	400,940.00	846,100.00

3.3. Бараа материал

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Бараа	10,600.00	10,600.00
Нийт дүн	10,600.00	10,600.00

3.4. Урьдчилж төлсөн төлбөр/тооцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Бусад урьдчилж төлсөн зардал	1,598,000.00	8,516,521.00
Нийт дүн	1,598,000.00	8,516,521.00

3.5. Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Барилга, байгууламж	10,563,000.00	10,563,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,690,080.00)	(2,112,600.00)
Нийт дүн	8,872,920.00	8,450,400.00

Тайлант онд нийт 422.5 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцож, ерөнхий ба удирдлагын зардалд тайлагнасан байна.

3.6. Бусад богино хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Бусад богино хугацаат өр төлбөр	72,544,506.00	97,444,506.00
Нийт дүн	72,544,506.00	97,444,506.00

3.7. Эздийн өмч

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Хувийн өмч	10,563,000.00	10,563,000.00
Нийт дүн	10,563,000.00	10,563,000.00

3.8. Борлуулалтын орлого болон борлуулалтын зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	-	-
Борлуулалтын бүтээгдэхүүний өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	-	-

3.9. Ерөнхий ба удирдлагын зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	2,917,928.00	1,910,856.00
Томилолтын зардал	214,000.00	278,349.00
Шуудан холбооны зардал	-	83,300.00
Мэргэжлийн үйлчилгээний зардал	10,103,000.00	13,461,000.00
Элэгдэл, хорогдлын зардал	422,520.00	422,520.00
Шатахууны зардал	952,126.00	2,022,076.00
Бусад үйл ажиллагааны зардал	35,440.00	198,500.00
Нийт дүн	14,645,014.00	18,376,601.00

Тайлант хугацаанд ерөнхий ба удирдлагын зардал 18,376.6 мянган төгрөг байна. Зардлын 73.3 хувь буюу 13,461.0 мянган төгрөг нь мэргэжлийн үйлчилгээний зардал, 10.4 хувь буюу 1,910.9 мянган төгрөг нь албан татвар, төлбөр, хураамжийн зардал, 11.0 хувь буюу 2,022.1 мянган төгрөг нь шатахууны зардал, харин үлдсэн 5.3 хувь буюу 982.6 мянган төгрөг нь элэгдэл, хорогдлын зардал болон бусад үйл ажиллагааны зардал байна.

3.10. Бусад зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Бусад зардал	5,100.00	-
Нийт дүн	5,100.00	-

3.11. Орлогын татварын зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Орлогын татварын зардал	-	-
Нийт дүн	-	-

3.12. Холбоотой талуудын ажил гүйлгээ

Санхүүгийн тайлангийн зорилгоор талууд нь НББОУС 24 буюу "Холбоотой талын тодруулга"-д тодорхойлсноор хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол холбоотой талууд гэж тодорхойлно. Холбоотой талуудын магадлалыг авч үзэхдээ хуулийн хэлбэрээс илүү эдийн засгийн холбоо хамаарлыг авч үзнэ гэж заасны дагуу холбоотой талуудын мэдээллийг татварын тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт тайлагнах үүрэгтэй.

3.13. Балансын дараах үйл явдал

2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2026 оны 2 дугаар сарын 10-ны өдөр хүртэл "Дэвшил мандал" ХК-ийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулах шаардлагатай үйл явдал гараагүй байна.

Ахлах аудитор



Ш.Уянга

2026 оны 2 дугаар сарын 10-ны өдөр



ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

“ДЭВШИЛ МАНДАЛ” ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛСОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

УЛААНБААТАР ХОТ
2026 ОН



“ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК

2026 оны 2 сарын 10 өдөр

Монгол улс 14230, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Парисийн гудамж-42, Ай Си Тауэр 607 тоот
Утас: 88472789, 88112654
И-мэйл: leaderaudit.20@gmail.com

“ДЭВШИЛ МАНДАЛ” ХК-ИЙН УДИРДЛАГАД

Удирдлагад хүргэх захидал

Бид танай байгууллагын 2025 оны жилийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ. Аудит хийх явцад санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад цаашид анхаарах асуудлыг энэхүү захидлаар хүргүүлж байна.

Санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцэтгэсэн горимоор бидэнд ажиглагдсан зүйлүүдийг удирдлагад хүргэх зорилгоор энэ захидлыг толилуулж байна. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан болно.

Цаашид компанийн дотоод хяналтыг бүрдүүлэх, сайжруулахад удирдлагад туслах зорилгоор дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжийг зөвхөн компанийн удирдлагад зориулан бэлтгэснээс бусад зорилго агуулаагүй болно.

ХҮНДЭТГЭСЭН
ЗАХИРАЛ



П. ШАРАВХОРОЛ

ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн тухай

Бодит байдал:

Компани нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрийн үйл ажиллагаандаа тохируулан тодорхойлж, бодлогын баримт бичиг боловсруулан, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах үүрэгтэй. Тухайлбал татварын багц хуулиудын өөрчлөлт болон Сангийн сайдын Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журмуудыг шинэчлэлүүдийг тусгаж мөрдөх үүрэгтэй.

Санал, зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн НБББББ-ийг баталж, мөрдөж ажиллана." мөн НББОУС-8.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа-д "Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулахад аж ахуйн нэгжийн гаргасан тусгай зарчим, суурь, дүрэм, журам ба практик үйл ажиллагаа юм" гэж тус тус заасан байна.

2. Үнэ шилжилтийн тайлангийн тухай

Бодит байдал:

Монгол улсын Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиуд 2020 оноос шинэчлэгдэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд эдгээр хуулиудаар аж ахуйн нэгж байгууллагууд нь Үнэ шилжилтийн тайланг гаргах үүрэг хүлээсэн.

Санал, зөвлөмж:

Татварын ерөнхий хуулийн 37, 38 дугаар зүйл болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйл, Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/133 тушаалаар батлагдсан "Тайлангийн маягт, хавсралт мэдээ нөхөх заавар"-ын дагуу Үнэ шилжилтийн тайлангуудыг бэлтгэж, тайлагнах. Арга аргачлалыг, ялангуяа хамаарал бүхий этгээдүүдтэй хийсэн аливаа хэлбэрийн ажил гүйлгээг зах зээлийн үнээс өөр үнээр хийсэн бол жишиг үнээр хэрхэн тооцох тухай дээрх зааварт нийцүүлэн, нарийвчилсан бодлого тодорхойлж, компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаж, тууштай мөрдөх.

Иймд хуулийн дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ шинэчлэн баталж, мөрдөх.

3. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл баталгаажуулах тухай

Бодит байдал:

2025 оны санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгө нийт 16,527,659.00 төгрөг байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг улирал, жилийн эцэст бэлэн мөнгөний тооллогын баримтаар баталгаажуулж байх ёстой.

Санал, зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,” гэсэн заалтын дагуу бэлэн мөнгөний тооллогын баримтаар баталгаажуулалтыг хийж санхүүгийн байдлын тайланд тусгах.

4. Өглөгийн тухай

Бодит байдал:

2025 оны санхүүгийн байдлын тайланд бусад богино хугацаат өр төлбөр нийт 97,444,506.00 төгрөг байна. Авлага, өглөгийн үлдэгдлийг улирал, жилийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, санхүүгийн тайланд тусгах ёстой.

Санал, зөвлөмж:

Дансны өглөгөд бизнесийн үндсэн үйл ажиллагааны явцад бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан бараа, хангамжийн зүйлс, үйлчилгээний үнийн төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллана”, 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтын дагуу тооцоо нийлсэн актаар баталгаажуулалтыг хийж санхүүгийн байдлын тайланд тусгах.

5. Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох тухай

Бодит байдал:

Компани нь татварын тайлангаар алдагдалтай бол салбар харгалзахгүйгээр дараагийн татварын жилээс эхлэн 4 жилийн хугацаанд ирээдүйд шилжүүлэн тооцно.

Санал, зөвлөмж:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19.2 *“Харьяалах татварын албаар баталгаажуулсан ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг тухайн алдагдал гарсан татварын жилийн дараах дараалсан дөрвөн жил бүр албан татвар ногдуулах орлогын нийт дүнгийн 50 хувиар хязгаарлан хасаж тооцно.”* гэсэн заалтын дагуу нэгээс илүү татварын жилд алдагдал гарсан тохиолдолд алдагдал гарсан жилийн дарааллаар албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.